

## ТҮҮХ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Л. Лувсанчүлтэм

**ОРОСЫН 1905 ОНЫ ХУВЬСГАЛ МОНГОЛД  
НӨЛӨӨЛСӨН НЬ**

1905 онд Орос оронд болсон хөрөнгөтний анхны ардчилсан хувьсгал нь олон улсын хувьсгалт хөдөлгөөнд үламжхэн ач холбогдолтой үйл явдал болсон билээ. Европад капитализмын эсрэг ажилчин ангийн хувьсгалт тэмцэл өрнөхөд хүчтэй нөлөөлсөн ба Ази тивийг сэрээж, колони ба хагас колонийн ард түмэн, түүний дотор монголын ард түмнийг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд уриалан дуудсан байна. Оросын энэхүү хувьсгалаас өмнө монгол орон нь жинхэнэ дундад эртний байдалд оршиж байсан бөгөөд өөр бусад олонхи улс үндэстнээс илүү хоцрогдсон байв. Монголчуудын энэ хоцрогдсон зогсонги байдал хэзээ ч өөрчлөгдөж хувирахгүй юм шиг харагдаж байжээ.

Гэтэл ингэж дундад эртний байдалд оршиж манж-хятадын дарлалд нэрвэгдэж байсан малчин ардууд Оросын хувьсгалын нөлөөгөөр эрх чөлөөнийхөө төлөө тэмцэж эхэлсэн билээ. Энэ тэмцэл хөдөлгөөн нь эхэн үедээ төдий л тод хурц бус байсан боловч сүүлдээ манжийн мэдлээс салах гэсэн тодорхой зорилго бүхий хөдөлгөөн болон хувираад цаашид өрнөхдөө тус орны хамгийн алс бөглүү зах хязгаарын хошуу, сумын ардууд хүртэл татагдан оролцож хөдөлгөөний цар хүрээ өргөжин тэлээд даруй бүх Монгол орны асуудал болж иржээ.

В.И.Ленин «Ази сэрсэн нь» гэдэг өгүүлэлдээ бичсэн нь «Дэлхийн капитализм, Оросын 1905 оны хөдөлгөөн хоёр нь Азийг бүрмөсөн сэрээв. Дундат зууны зогсонги байдалд зэрлэгшин хоцрогдсон олон зуун сая хүн ам шинэ амьдрал, хүний хамгийн наад захын эрх, ардчиллын төлөө босов»<sup>1</sup> гэжээ. Үнэхээр энэ үед монголчууд ил өнгөндөө манж хааны зарлигийг дагадаг нэртэй байсан боловч эчнээ далддаа түүний мэдлээс гарах гэсэн илэрхий шинж үүсч, манж амбан хятад түшмэдийн зарим тушаалыг биелүүлэхгүй шууд зөрчдөг үзэгдэл олон болов.

Жишээ нь: Манжийн хуулиар тогтоосон улсын өртөөний албыг таслахаас эхлээд хилийн харуулын албанаас зайлсхийх, манж, хятад цэрэгт зориулсан татварын мөнгө, юмыг дутуу хагас өгөх буюу огт өгөхгүй байх, эсвэл муу чанарын мөнгө, юмаар орлуулах, цэргийн уналгын агт морьд болон зэр зэвсэг зөөх тэмээ тэргийг нийлүүлэн өгөхгүй саатуулах, цэргийн хүнс хоолны хонь, үхрийг цаг тухайд нь олгохгүй удаан хүлээлгэх, эсвэл хөгшин туранхай муу малаар ор нэр болгон бөглөх, тэдний зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд алба хаахыг дургүйцэж, цэргийн албыг хаяж явчих, ялангуяа манжийн амбан захирагч, түшмэдийн өөдөөс эсэргүүцэх тэдний залхаан цээрлүүлэх цагдаа, цэрэг болон хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчидтэй хэрүүл маргаан хийх буюу тэднийг зодож жанчих хүртэл элдэв янзын хэлбэрээр илэрч байжээ.

<sup>1</sup>В. И. Ленин, зохиолууд, УБ. 1966 он, 19-р боть, 72-р тал.

1905 онд хятадын Жили мужийн амбан Юань Шикай<sup>2</sup> Бээжин балгасын цэргийн ангид хэрэглэх бие том, шүд залуу, хүч тарган бөгөөд зээрд, хар, хээр гурван зүсмийн агт морь 6000<sup>3</sup>-ыг монголоос бэлтгүүлэн авах гэж тушаасанд халхчууд сөрж мэдүүлсэн нь: «бид цэрэг дайны хэрэгцээнд асар олон тооны тэмээ, морь үхэр нийлүүлсэн бөгөөд эдүгээ манай мал сүрэг их л цөөрөв. Одоо морьд өгч чадахгүй» гээд нэг ч морь өгсөнгүй. 1910 онд Лифаньюанаас<sup>4</sup> хятад газар төмөр зам тавихад Халхаас 100000 лан мөнгө<sup>5</sup> «зээлдэн» авахаар зарласанд олон хошуу цөм татгалзаж, манай ардууд улсын өртөө болон харуул-цэргийн албанд аль байдаг юмаа өгсөөр хоосров. Одоо зээлдүүлэх мөнгө алга гэж хариу мэдэгджээ. Энэ мэтээр эсэргүүцсэн албан баримт бичиг олон бий. Халхчуудын зүгээс иймэрхүү сөрүү эсэргүүцэл олонтоо гаргадаг болсон учир манж хятад ноёд ч монголын байдлаас битүүхэн болгоомжилдог болж, дээрх мэтийн тушаалаа цаашид дахин давтан нэхэн шаардвал дээсний эрч хэтрээд тасарч салахад хүрүүзэй гэж айгаад хааяа дуугүй өнгөрдөг болов. Манж-хятадыг эсэргүүцсэн их хүрээний ардууд ба ядуу лам нарын тэмцэл 1905-1907 онуудад гарч\* сар жил өнгөрөх тутам улам бүр олныг хамарсан бослого тэмцлийн хэлбэртэй болж иржээ.

1910 оны хавар Халхын их хүрээний сайдаар томилогдсон Сандо амбан тушаал хүлээн авснаа зарлаад нэг сар болоогүй байтал хятадыг эсэргүүцсэн олны дайралтыг биеэр үзсэн нэгэн сонин хэрэг гарсан байна. Энэ хэрэг явдал нь мөн оны арван хоёрдугаар сарын 27-нд болжээ.

Их хүрээний Гандангийн хэдэн лам нар «их чөлөө» гэдэг өргөн гудамжны Да Ию хэмээх пүүснээс бараа худалдан авахдаа үнэ асар өндөр гэж маргалдан зөрсний улмаас монгол лам нар худалдаачин хятад нарын хооронд хэрүүл үүсч, түүнд бас хүрээний харчуул-ардууд оролцсон учир уг хэрүүл улам ширүүсэн харилцан жанчилдаж, пүүсний бараа юм, эдлэл хогшлыг хэмхэцсэн бөгөөд тэр даруй зүг зүгээс хүмүүс нэмэгдэж, гудамжаар дүүрэн олон хүний эсэргүүцэл хөдөлгөөн болон хувирчээ. Лам нарын зарим нь Гандангийн зүүн хажуу дээр бөөгнөрч, «шулмасыг хөөн тонилгох ном», «хар хятадын тотгорыг арилгах ном» гэгч хараал зүхлийн ном уншиж, алга ташин шороо цацаж байхад бусдууд нь хятад худалдаачид руу чулуу шидэн, модоор жанчиж байв. Энэ зодооныг зогсоохоор зах-зээл цагдагч морьт цагдаа нар давхилдан очсонд зодоон цохион улам ихдэж цагдаа нарын өөдөөс ардууд чулуун мөндөр зай завсаргүй буулган, тэдний заримыг шархдуулж байжээ. Хятадуудыг өмөөрч монгол хүмүүсийн эсрэг галт зэвсэг хэрэглэсэн хүрээний цагдан сэргийлэхийн дарга Амар залан тэргүүтэй хэдэн түшмэдийг зодоонд оролцсон ардууд үзээд уур хилэн бадарч тэдгээрийг барин авч, ясыг нь хэмхэртэл зоджээ. Энэ Амар залан гэгч амбан яамны эрх сүрээр ард олныг айлган зовоож байсан харгис түшмэл мөн тул тэр цагийн ардууд «Аюул аюулаас айхгүй. Амар залангийн аюулаас айна. Амбан амбанаас айхгүй, Амар залангийн аюулаас айна» гэж дуулцгаадаг байв.

<sup>2</sup>Гоминьданы засгийн үед Хятадын Ерөнхийлөгч болсон хүн.

<sup>3</sup>УТТА ф№— 1, ХН 2257, т, 108,

<sup>4</sup>Гадаад мужийг засах журган буюу Монгол, Төвд, Хотон үндэстний хэргийг эрхэлсэн яам.

<sup>5</sup>УТТА. ф №— 1. ХН 2259 Т. 30.

\*Б. Ширендыб. Монголия на рубеже XIX—XX веков. УБ. 1963. 70-р тал С. Пүрэвжав. Хувьсгалын өмнөх их хүрээ УБ. 1961. 156—157-р тал. тодордорхой үзнэ үү.

Сандо амбан энэ гарсан хэргийг бие тулж байцаан үзэхээр өөрийн яамны бүхий л бичиг, цэргийн түшмэд ба Сюаньхуа\* цэргийн нэг салааг дагуулж, их сүр бадруулан хүрэлцэн очсонд өнөө олон хүмүүс сайхь амбаныг үзмэгц харин дуу шуугиан нэн чангарч амбаны суусан жууз тэрэг рүү халдан дайрч, чулуу нүүлгэн жуузны цонх шилийг хагалаад «амбан ноён зайлтугай» гэж хашгиралджээ. Сандо амбан түүний санаанд огт ороогүй ийм «байлдаантай» гэнэт учраад тэрээр ихэд айж сандран санаа зүрх нэгмөсөн унаж, мягуйнаас айсан хулгана адил амь зулбан буцаж зугтаасанд бусад дагуул түшмэд, цэргүүд нь ташуур шилбүүрийн амт» үзсэн сүрэг мэт цөм хойш зугтаасан болой. Энэ тухай БНМАУ-ын түүх бичигт тэмдэглэсэн нь «1910 оны дундуур их хүрээнд хэдэн зуун ард, лам нар Да Ию гэгч хятад пүүсийг довтлон дайрч, манж-хятадын мөлжигчид монгол орноос зайлтугай гэж уриа цуурайтуулснаар эрх чөлөөний тэмцэл шинэ шатанд гарсны илрэл болсон»<sup>6</sup> гэжээ. Энэ болсон хэрэг явдалд амбан захирагчийн хорсол хилэн бадарч, хятад иргэдийн өөдөөс ёс зүйгүй авирлаж, олныг дагуулан зодоон гаргасан этгээдийн толгойлогчийг барьж өгөхгүй өмгөөлөн дарагдуулав гэж их хүрээний эрдэнэ шан зудбыг буруушааж тушаалаас огцруулан хүрээнээс хөөн зайлуулаад албан хэрэгт үүрэг оролцуулахгүй болгон шийтгэснээс гадна хэрвээ дахин энэ мэт олноор бүлэглэн хэрэг гүйвээн дэгдээвэл цэргийн хүчээр нухчин дарж байхын тул халхын зүүн аймгуудын цэргийн жанжин нарын цэрэг захирах эрхийг болиулж, монгол цэргийн захиргааг өөрийн гарт бүрэн оруулан авахаар шийдээд уг санаагаа нуун далдалж, хууран мэхлэхийн тул эртний түүх домог дурдан их нуршуу үг бичиж зарласан нь: «Монголчууд дээр үед дайсан лугаа байлдахдаа хэтийдсэн гавьяа байгуулж сүр жавхлангаар дэлхий дахинд гайхуулж байв. Ойрноос үзвэл урьдын баатар идэрхэгийн амьсгал нь буурай дорой болон хувирчээ. Монголын олон хошууны цэрэг хэдүй бэлэн буй нэртэй боловч яаруу бачим хэрэг тохиолдвол огт хэрэггүй мэт болжээ. Монгол газрыг сахин хамгаалах нь тэргүүн зэргийн чухал болой. Сюаньхуа цэрэг, хүрээний цагдан сэргийлэх цэргийн хороог цөм шилжүүлэн өгч захируулсугай»<sup>7</sup> гэжээ. Сандогийн энэ оролдлого биелж амжаагүй байж байтал манж-хятад ноёдын сэтгэл санааг улам гүнзгий түгшүүлсэн үйл явдлын мэдээнүүд гарч байв.

1910 оны сүүлчээр Чуулалт хаалга хот дахь Гусай амбанаас<sup>8</sup> их хүрээний амбанд илгээсэн нэгэн нууц бичигт өгүүлсэн нь «эдүгээ Гадаад Монголын нутагт идэр эрс, сайн морь, хурц зэвсэг их л бэлдсэн бөгөөд манж, хятад хүмүүсийг хэрмийн<sup>9</sup> дотор хөөн оруулаад их Чин гүрний хууль дүрмийг хэрэгсэхгүй болгох хэмээмүй. Эдгээр үг бүх Монгол газар дэлгэрээд гагцхүү...хөдлөх цагийг хүлээж буй хэмээмүй. Эрт орой алин боловч урван самуурна хэмээх бөгөөд энэ нь үнэхээрийн сэжигтэй тул цаг ямагт сэрэмжлэн чанга нарийн байцааж хэрэг дэгдээхгүй болгохыг чухалчилна уу»<sup>10</sup> гэсэн байжээ.

Ар монголд үйл хэргийн явц иймэрхүү болж байсан жилүүдэд Манжийн ноёрхол, хятад түшмэдийн эрх мэдэл бараг хоосон нэр болж Хуандий хааны урьдын аугаа их сүр хүчнээс гагцхүү ихэмсэг цол гуншин үлдсэн бөгөөд түүний ёс дэглэм нийт Монгол даяар бүр устахын ёр тэмдэг илэрхий

\*Сюань хуа цэрэг гэгч нь их хүрээг хамгаалах нэрийдлээр суулгасан нэгэн хороо хятад цэрэг юм. Энэ хорооны цэргийг 1871 оноос эхлэн ээлж дараагаар солихдоо Жили мужийн Сюань-хуа сянь-аас нөхөн ирүүлдэг байсан учир тэгж нэршжээ.

<sup>6</sup>БНМАУ-ын түүх, дэд боть УБ, 1968. 411 -р тал

<sup>7</sup>Ф № 1. ХН 2454 тал 397—398.

<sup>8</sup>Цахарын 8 хошууг захирсан амбан.

<sup>9</sup>Түмэн газрын урт Цагаан Хэрэм гэж алдаршсан хятадын их хэрэм мөн.

<sup>10</sup>А. Ф. 4-26-457.

болж, монголчууд манж хятад ноёдын өмнө сөгдөхгүй, тэднээс айн сүрдэхгүй, тэдэнтэй ил тэмцэх болсноор үл барам Чин гүрнээс бүрэн тусгаарлах гэсэн хүмүүс Ар, Өвөр монголын алинд ч арвин болж онцгой сэжиг түгшүүр төрүүлсэнд манжийн эрх баригчид хирдхийн цочиж, монгол оронд алдаж болзошгүй болсон байр сууриа бататгахын тул монголын талаар явуулж байсан төрийн бодлогоо яаравчлан хянаж үзэж, зарим нэгэн «буулт» хийх дүр үзүүлэн уг чанартаа түрэмгийлэн колоничлох шинжтэй шинэ засгийн бодлого» гэгчийг зарлан тунхаглажээ. Түүнд бичсэн нь:

-Монголын их хүрээнд хотын захиргаа (Муниципалитет) байгуулна.

-Их хүрээнд олны санал хүлээн авч байх хороо байгуулна.

-Төв Засгийн газрын хуралд Монголоос зөвлөн хэлэлцэгчийг<sup>11</sup> оролцуулна.

-Монголын эдийн засгийг хөгжүүлэхийн тул ашигт малтмалын орд уурхай нээнэ.

-Монголд цахилгаан мэдээ, телефон утас, төмөр зам байгуулна.

-Монголоос есөн цагаан,<sup>12</sup> бурхан, хадаг, бодон гахай, зүр болон үст алба<sup>13</sup> жил бүр авч байсныг зогсооно гэжээ. Эдгээр нь колоничлолын явуулахын анхны эхлэл байв. Цаашид монгол орны хойчийг улам сайжруулна гэж олонтоо амлаад ам хамхихгүй ятган ухуулж байсан бөгөөд түүндээ Ар, Өвөр Монгол дахь манж-хятадын талыг баримтлагч, тэд- ний үг санааг эвсэн зөвшөөрөгч, тэднийг аялдан дагагч этгээдийг өргөп ашиглаж байв. Гэвч монголчуудын бодол санааг өөрчлөн, монголын үндэсний тусгаарлах хөдөлгөөнийг таслан зогсоох гэсэн тэдний бодлого нь нуран унажээ. Иймд Лифаньюуаний амбан түшмэд урьдын амалснаа ичгүүр сонжуургүй тэрслэн зөрчиж, монголын талаархи хуучин тогтоол бөгөөд олон жилийн турш сахиж ирсэн хууль дүрмийг сэмхэн өөрчлөн халаад монголчуудыг хятад хүмүүсийн дотор живүүлэн уусгах санаа бүхий төлөвлөгөө боловсруулан эхэлжээ. Түүнд бичсэн нь:

-Урьдын хуульд хятадын иргэд монгол хүмүүсийн малын бэлчээрийг дураар эзэмшин, тариалан үйлдэж үл болно гэснийг хэрэгсэхгүй болгох.

-Монголын албан бичигт хятад бичиг хэрэглэх буюу монгол хүнд нэр өгөхөд хятад үг үсэг хэрэглэхийг дураар болгоно.

-Хятад хүн монгол охидыг эм болгон авч үл болно гэсэн зүйлийг хасан арилгаад хятад-монгол харилцан ураг болж болно.

-Монгол хүн хятадтай ураг бололцвол харьяат захиргаанаас мөнгө шагнан өгч сайшаан тэмдэглэнэ.<sup>14</sup> гэх мэтээр зуун зүйлийн зальхай санаагаа нээж, баллан устгах төлөвлөгөө гаргаж байсан байна. Бас үүний зэрэгцээгээр Монголын үндэсний чөлөөлөх хөдөлгөөний зохион байгуулагч, биечлэн оролцогч идэвхитнүүдийг барин авч устгахаар хятадын тагнуулчин эрэлчин үүгээр түүгээр бэдрэн хайж байв. Гэвч тэдний хамаг хорт бодлогыг ард түмэн эсэргүүцэн няцааж байв.

Энэ бол нэг талаас монголын ард түмний үндэсний ухамсар дээшилж, эрх чөлөөний төлөө тэмцэл өрнөж байсан, нөгөө талаас манжийн ноёрхол бүрмөсөн сөнөхийн даваан дээр гарч, түүнийг аврах хүч байхгүй болсны гэрч мөн бөгөөд манжийн хаант засаг, төрийн ёс дэглэм нийт даяар ялзран өмхөрч байсныг харуулжээ.

<sup>11</sup>Монгол төлөөлөгч

<sup>12</sup>Есөн цагаан гэдэг нь мөнгөн буйлтай, цагаан булгаар чимсэн цагаан зүс- мийн тэмээ нижгээд, шар торгон ногттой, 5 өнгийн хадгаар чимсэн цагаан морь наймаадыг аймгууд жил бүр манж хаанд барьж байсныг хэлжээ.

<sup>13</sup>Үст алба гэдэг нь Алтай, Алган нуурын урианхайчуудаас тэдний өрхийн тоонд оногдуулан жил бүр 4000 булга ба үлэмж тооны хэрэм авч байсныг хэлжээ.

<sup>14</sup>Ф. № 1. ХН 2457, 397—398-р тал.

МАХН-ын товч түүхэнд бичсэн нь: «1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний ачаар Монгол орон манжийн олон зуун жилийн ноёрхлоос ангижирсан нь Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн түүхэнд 7см алхам болсон юм»<sup>15</sup> гэжээ. Үнэхээр 200 илүү жил хайрдан зогссон Монголын төрийн хөлөг онгоц энэ хөдөлгөөний үр дүнд урагш хөдөлж, хоёр зууны турш хумигдан хэвтсэн соёмбот туг өндөр мандсан бөгөөд 1921 оны монгол ардын ялгуулсан их хувьсгалын өмнөх угтвар нөхцөл болсон байна.

**Л. Лубсанчултум**

## РУССКАЯ РЕВОЛЮЦИЯ 1905 г. И МОНГОЛИЯ

### (Резюме)

Под воздействием первой русской революции 1905 года народы Азии, в том числе монгольский народ, очнулись от векового политического сна и поднялись на национально-освободительную борьбу. В своей начальной стадии национально-освободительная борьба в нашей стране еще не достигла острых классовых форм, но она вполне определенно преследовала цель освободиться от маньчжурского господства, гнёта китайских чиновников и торговцев и, в своем дальнейшем развитии, охватывая самые окраинные районы страны с ее различными прослойками населения, превратилась в весьма существенный фактор общемонгольского значения.

Борьба монголов против маньчжуро-китайской эксплуатации принимала самые различные формы. Имели место массовые дезертирства и нарушения установленных порядков маньчжурской империи, срыв государственной конно-уртонной службы, побеги с пограничной караульной службы, нападения на склады и магазины китайских купцов и ростовщиков. В качестве примера автор освещает историю столкновения аратов и духовнства в Хурене (ныне Улан-Батор) в 1910 г. с китайскими купцами к маньчжурскими властями, а также проблемы монголо-китайских отношений того периода, нашедшие свое отражение в материалах ЦИА МНР.

Несмотря на все ухищрения «политики нового курса» маньчжурских властей, народно-освободительное движение монгольского народа им остановить не удалось. Оно стало мощным подготовительным фактором освободительной борьбы монгольского народа и предвестником монгольской народной революции 1921 года.

<sup>15</sup>МАХН-ын товч түүх. УБ., 1967, 8-р тал.